



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/07

Хажуу шинэ үс

Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 2022 оны жилийн эцсийн хүн амын тооллогын дүнг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. XVII жарны "Үзэсгэлэн болгогч" хэмээх Туулай жилийн билгийн тооллын хаврын тэргүүн сарын сар шинийн баярыг тохиолдуулан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Сумын Засаг дарга хүндэтгэл үзүүлэх ахмад настнуудын нэрсийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

3. Хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д үүрэг болгосугай.

4. Хүндэтгэлд зарцуулах 750,000.00 (Долоон зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох), Нягтлан бодогч (У.Сүнжидмаа) нарт зөвшөөрсүгэй.

Хавсралт...хуудастай.

ЗАСАГ ДАРГА



ТАРИУНАА

482301007